


Та орогнол хүсэлтийн хариуд **хүлээн авахийг татгалзсан** буюу **цагаачлахыг татгалзсан сөрөг шийдвэр** авсан бөгөөд, уг шийдвэрийг давж заалдаагүй, эсвэл давж заалдсан хэдий ч мөн татгалзсан хариу авсан. Танд энэхүү мэдээллэх хуудсаар дамжуулан таны эрхийг тайлбарласан болно. Энэхүү мэдээлэл нь Швейцар улсад орогнол эрэгчид туслах төрийн бус байгууллагаас орогнол эрэгчид болон цагаачлахыг хүсэгчдийн эрхийг хамгаалахаар зохиогдсон болно.

Цагаачлах асуудлыг шалгах нь:	<ul style="list-style-type: none"> Таны цагаачлах асуудал бүрэн шалгагдаж дууссан ба, та үл ойшоосон хариу шийдвэр авсан бол, эрх бүхий байгууллагаас таныг тус улсыг орхин гарахыг шаардана. Иймд танд тус хүлээн авах газраас нэг өдөр (24 цаг хүртэл) Швейцар улсын нутагт зорчих галт тэрэгний тасалбар олгоно.
Цагаачлах эрхийг тань зогсоосон бол:	<ul style="list-style-type: none"> Та Швейцар улсад хууль бусаар амьдарч байна. Та байрлаж буй газраа орхин ёстой бөгөөд, цаашдаа өөрийнхөө төлөө өөрөө бүгдийг хийх болно. Тус улсыг орхин гарах хүртлээ цагаачлах асуудлыг тань шалган шийдвэрлэсэн бүх бичиг баримтаа хувьдаа хадгална уу. Эрх бүхий байгууллагуудаас таныг тус улсыг орхин гарахыг үргэлж шаардах болно. Та ажил хийх эрхгүй. Магадгүй таныг тус улсад хууль бусаар ошин буй шалтгаанаар хуулийн шийтгэл ноогдуулж болно.
Яалтгүй байдлын тусламж - Танд мөнгө байхгүй юу?	<ul style="list-style-type: none"> Хэдийгээр та Швейцар улсад хууль бус оршин байгаа хэдийч, тус улсыг орхин гарах хүртлээ яалтгүй байдлын тусламж авах эрхтэй. Уг тусламжид таны орон байр, хоол хүнс, хувцасны асуудал болон эмнэлгийн яаралтай түргэн тусламж багтана. Та тус улсын нийгмийн тусламжийн аль ч байгууллагад өөрийн биеэр хандаж өргөдөл гаргаж болно. Таны өргөдөлийн дагуу ямар хариу өгөхийг муж улс бие даан шийднэ. Таныг гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн газарт бүртгүүлэхийг юуны өмнө шаардана. Тэнд таны гарын хурууны хээг авч, танд холбогдох бичиг баримтыг шалгана. Таныг шууд албадан саатуулж болзошгүй. Ихэвчлэн тохиолдолд таны тус улсыг орхин гарах асуудлыг хариуцсан муж улсад хандаж яалтгүй байдлын тусламжийн өргөдөл гаргахыг таниас шаардана. Тухайн хариуцсан мужийн нэр нь цагаачлалын албаны шийдвэрийн эцсийн хуудас дээр байгаа. Эрх бүхий байгууллага нь танд туслахаас татгалзсан бол, нотолгоог бичгээр гаргуулан аваарай. Ийм тохиолдолд та гомдол гаргаж болно. Ямар нэгэн хуулийн өмгөөлөгчид хандах хэрэгтэй.
Албадан саатуулах нь:	<ul style="list-style-type: none"> Эрх бүхий байгууллагад хандмагц тань, таныг албадан саатуулж болзошгүйг та бас тооцох хэрэгтэй. Хэрэв та албадан саатуулагдсан бол ямар нэгэн хуулийн өмгөөлөгчтэй холбоо тогтоох, энэ тухайгаа өөрийн төрөл төрөгсөд, найз нөхөддөө мэдэгдэх эрхтэй. Таныг баривчлан саатуулснаас хойш 4 хоногийн дотор хуулийн шүүгч таны баривчлагдсан саатуулагдсан нь хуулийн дагуу эсэхийг магадлан шалгах ёстой.
Швейцар улсыг орхин гарах нь:	<ul style="list-style-type: none"> Эрх бүхий байгууллагаас таныг өөрийн дураар эх орондоо буцахыг хүлээнэ. Хэрэв та эх орондоо өөрийн дураар буцахыг хүсвэл, даруй гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн газарт мэдэгдэх хэрэгтэй. Та эх орондоо буцахад шаардагдах бичиг баримтыг өөрийн орны элчин төлөөлөгчийн газарт хандан авч болно. Ихэнх улсын элчин төлөөлөгчийн газар тус улсын нийслэл Бэрн хотод байрладаг. Мөн дипломат төлөөлөгчийн газрууд Женев хотод байрладаг. Таныг буцахад үзүүлэх тусламж болон зөвлөлгөөг харъяа муж улсаас асууж лавлаарай.
Нэмэлт заалтууд:	<ul style="list-style-type: none"> Та гэмт хэрэгт холбогдохоос зайлсхийгээрэй. Та өөрийн нөхцөл байдлаа төрөл төрөгсөд, танилууддаа байнга мэдэгдэж байна уу. Хуудасны арын нүүрнээс орон нутгийн байгууллагуудын талаарх мэдээллийг харна уу.

zum ausfüllen\асуултыг бөглөнө үү 

Antrag auf Nothilfe\ Яалтгүй байдлын тусламж авах хүсэлт

Name\Нэр: _____ N-Дугаар.: _____

Asylentscheid vom\Цагаачлалын албаны шийдвэрийн он, сар, өдөр : _____

Би өөрийн амьдралын наад захын хэрэгцээг хангах болон өөрийгөө тэжээх чадваргүй хүнд байдалд байгаа гэж үзэж байгаа учир тус улсын үндсэн хуулийн 12-р зүйлд заасны дагуу хүнд байдлаас гарахад туслах яалтгүй байдлын тусламж авахыг хүсч байна.

Datum, Unterschrift\ Он сар өдөр, гарын үсэг _____

Танд яалтгүй байдлын тусламж үзүүлэх байгууллага

Nothilfe – offizielle Anlaufstelle / Aide d'urgence – Bureau officielle / Ufficio competente per le prestazioni di assistenza / Basic Assistance – official Aid / Ayudo oficial / Entidade oficial de apoio a pessoas em situação de necessidade / Танд буцалтгүй тусламж үзүүлэх байгууллага / Özel danışma yada yardım büroları / Первая помощь – официальное учреждение

அரசசார்பான அவசரஉதவி நிலையங்கள்

نقطة المعونة في حالات الضرورة لدى الجهات الرسمية

مراكز خدمات اضطراری دولتی:

Хувийн лавлах товчоод буюу тусламжийн газрууд

Private Auskunfts- oder Hilfsstellen / Service de consultation ou Aide privée / Consulenze private / Privat consultation or Aid / Ayudo particular o servicio legal / Entidades particulares de informação ou apoio / Хувийн лавлах товчоод буюу тусламжийн газрууд / Resmi makamlarin acil yardım büroları / Частные справочные бюро или вспомогательные учреждения

தனியார் தகவல் மற்றும் உதவி நிலையங்கள்

الانقطة الغير حكومية للاستعلامات والمساعادات

مراكز اطلاع رسائی و کمک رسائی خصوصی:

Албадан шахалтын үед тусламж үзүүлэх газар

Hilfe bei Zwangsmassnahmen (Gefängnis) / Aide en cas de «Mesures de contrainte» (détenion) / Consulenze per le misure coercitive (prigione) / Assistance in case of detention / Ayudo in caso de detención / Entidade de contacto para medidas coercivas / Албадан шахалт үзүлэх газар / Zorlayıcı tedbirler üzerine bilgi edinme ve danışma büroları (hapishane) / Помощь при

вынужденных мерах (тюрьма) / نقطة الاتصال الخاصة بالاجراءات الاجبارية

கட்டாய உதவி தேவைப்படும்போது தொடர்புகொள்ளக்கூடிய நிலையங்கள்

مراكز موقت شرايط اجباری و اضطراری:

Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх газар

Medizinische Hilfe (Spital) / Aide médicale (Hospital) / Aiuto medicale (Hospedale) / Medical Aid (Hospital) / Hastane /

Медицинская помощь (больница) **مراكز موقت شرايط اجباری و اضطراری:**